



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/680.

Ховд

Усан замын тээврийн талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 б, Усан замын тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аливаа осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор харьяа нутаг дэвсгэрийн гол, мөрөн, нуур цөөрөмд усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн улирлыг дуусгах, усан замын тээврийн үйл ажиллагааг 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дараа оны 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд зогсоосугай.

2.Усан замаар зорчигч, ачаа тээвэрлэхгүй байх талаар холбогдох зохион байгуулалтын арга хэмжээ авах, олон нийтэд сурталчлах, хяналт тавьж ажиллахыг холбогдох сумын Засаг дарга, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Л.Батбаяр/, Онцгой байдлын газар /Б.Алтанбадралт /, Мэргэжлийн хяналтын газар / П.Эрдэнэчулуун/-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Н.Ганзоригт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



02 03360

Zax A/680 Ch